



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 8/150

Мандалговь

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын ахмадын хорооны хүсэлтээр Монгол улсад ахмадын байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ойг тохиолдуулан 'Сайнцагаан сумын Одонтой ахмадуудаа алдаршуулж байна' зурган нийтлэлийг Дундговийн амьдрал сонинд хэвлүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хэвлэлийн зардалд шаардагдах 300,000 (Гурван зуун мянга)-н төгрөгийг Засаг даргын нөөцийн зардлаас гаргахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), Ня-Бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА С.БАТ-ОРГИЛ

